



I-XI/2022

Тархаасан: 2022 оны 12 дугаар сарын 13



Объектын түймэр 2022 оны эхний 11 сард 2792 удаа бүртгэгдсэн байна

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2022 оны эхний 11 сарын байдлаар 3912 болж, өмнөх оны мөн үеэс 272 (7.5%)-оор өссөн байна. Объектын түймэр 2022 оны эхний 11 сарын байдлаар 2792 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 400 (16.7%)-гаар, биологийн гаралтай аюулт үзэгдэл 185 болж, 63 (51.6%)-аар тус тус өссөн байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний 11 сарын байдлаар нийт 239 хүн амь насаа алдаж, өмнөх оны мөн үеэс 62 (20.6%)-оор буурсан байна.

ХҮСНЭГТ 1. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ², жил бүрийн эхний 11 сарын байдлаар

Үзүүлэлт	2019 I-XI	2020 I-XI	2021 I-XI	2022 I-XI	2022 I-XI
					2021 I-XI
					хувь
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	4 681	3 849	3 640	3 912	107.5
Газар хөдлөлтийн тоо	39	54	269	72	26.8
Объектын түймрийн тоо	3 908	2 919	2 392	2 792	116.7
Амь насаа алдсан хүний тоо	202	240	301	239	79.4
Учирсан хохирол, тэрбум төгрөг	48.7	108.2	22.5	28.9	128.4
Зарцуулсан зардал, тэрбум төгрөг	1.1	0.3	1.2	3.1	2.6 ¹

¹ Дахин их

² Корона вируст халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний 11 сарын байдлаар 28.9 тэрбум төгрөгийн хохирол учирч, 3.1 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, хортон шавж, мэрэгч тархах зэргийг хэлнэ.

Гамшиг: Аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.



Эх үүсвэр:

Онцгой байдлын ерөнхий газар;

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2023 оны 01 дүгээр сарын 14

Эдийн засгийн статистикийн
газрын даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч Ц.Тэгшжаргал
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын ахлах статистикч Б.Уянгаа
Утас : (976-51)-261563

